

Түүхчилсэн лавлах

Нэг. “ УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ ОНӨААТУГАЗАР”-ЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Орон сууц нийтийн аж ахуйг арчлан хамгаалах, хот тохижуулах ажлыг сайжруулах арга хэмжээний тухай Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 2-р сарын 06-ны тогтоолд заахдаа “Хот тохижуулах газрын харъяанд хот нийтийн аж ахуй, хорооллын зам талбайн ашиглалт, засвар тохижилт болон хот тохижуулах байгууллагуудын туслах үйлдвэрлэл эрхлэх, ”Хот тохижилтын трест”-ийг замын авто машин механизмын авто гражтайгаар аж ахуйн тооцооны үндсэн дээр шинээр зохион байгуулах үндэс суурь тавигджээ.

Улаанбаатар хотын АДХГЗ-ны шийдвэрээр “Хот тохижилт”-ын трестийн даргаар Доржпүрэв томилогдон ажиллаж байжээ.

Энэ тогтоол шийдвэрийн дагуу Авто замын Ерөнхий газрын дарга /Жиглий/-д даалгаж, тусгай комисс томилон Улаанбаатар хотын комисст дараах авто зам гүүр, машин механизм ажиллах хүчийг 1987 оны 2-р сард тусгай актаар хүлээлгэн өгөв.

Үүнд:

Асфальтон зам 362км

Хайрган зам 67 км

Гүүр 28

Мөн “Зам барилга ашиглалт”-ын трестээс Улаанбаатар хотын зам талбайн засварыг олон жил хариуцан гүйцэтгэж ирсэн Шажин, Мияа нарын 2 бригад, ажил хариуцсан мастерууд, инженер техникийн 63 ажилтан албан хаагч, замын зориулалтын машин механизм 9, авто самосваль 5, ачааны авто машин 2, нийт 21 тооны машин механизмтай, 1 сая 232,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад “Хот тохижилтын трест”-д шилжүүлсэн байна. Тухайн үед контор нь Энхтайвны гүүрний баруун талд, авто граж нь 2 буудалд байрлаж байжээ.

1987-1994 онд Авто зам, явган замын хавтан үйлдвэрлэх туслах үйлдвэр

Нийслэл хотын зам засвар, хорооллын доторх замын засварыг хийх замын бригад

Авто граж гэсэн гурван цех хэлтэстэйгээр нийслэлийн авто замын болон хорооллын доторх зам засварын ажлыг дангаараа хариуцан гүйцэтгэдэг байжээ.

1993 оны эхээр авто зам, явган замын хавтан үйлдвэрлэх туслах үйлдвэр компаний үйл ажиллагааны чиглэлээс хасагдсан тул нэр өөрчлөгдөн “Тохижилт компани” болж 1998 он хүртэл зам засварын ажлыг гүйцэтгэж байсан.

1992-1994 онд Гаанжуурын Нямцэрэн, **1994-1998** онд Бадмаарагийн Отгонсүрэн нар захирлын үүргийг гүйцэтгэсэн.

Түүхчилсэн лавлах

1998-1999 оны Ардчилал шинэчлэлтийн жилүүдэд бүтцийн өөрчлөлт хийснээр тухайн үеийн нэрээр “Гэрэлтүүлэг чимэглэл”, “Нөөц”, “Цэцэрлэгжилт” компаниудыг “Тохижилт” компанитай нэгтгэх Нийслэлийн засаг даргын захирамж гарсан. Ингэснээр хотын гудамж замын гэрэлтүүлгийг засварлах, шинэчлэх, мод сөөгийг ургуулах арчлан тордох, зам засварын ажлыг хийж гүйцэтгэх, нохой устгах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх болсон. Тухайн үед захиралаар Төмөрбаатарыг томилсон бөгөөд нэг жилийн дараа буцаад дээрх компаниудыг салгаж хуучин бүтэц зохион байгуулалтанд нь оруулсан.

1999 оны 9-р сард компани байгуулагдахдаа ажил үүргийнхээ чиглэлийн дагуу дүрмээ боловсруулан бүтэц орон тоог батлуулан “Улаанбаатар зам засвар компани” нэртэй болж захирлаар нь Бадмаарагийн Отгонсүрэнг томилсон. Тухайн үед тус компани Нийслэлийн гудамж, зам талбай хорооллын доторх зам засвар, арчлалтын ажлыг гүйцэтгэж байв.

Нийслэлийн засаг даргын 2000 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/65 тоот захирамжаар Авто зам барилгын “Улаанбаатар” компани Дохио үйлдвэрийн газрыг татан буулгаж “Улаанбаатар зам засвар” компанид нэгтгэснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэрлэн дохионы засвар үйлчилгээ, тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэх болсноор үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Тухайн үед 1,7 миллиард төгрөгийн үндсэн хөрөнгө, 50 сая гаруй төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 90-ээд ажиллагсад, 60 машин механизм, 50-иад тоног төхөөрөмж багаж хэрэгсэлтэй жилдээ 500 гаруй сая төгрөгийн ажил үйлчилгээг явуулах хүчин чадалтай байгууллага байжээ.

2001- 2005 он хүртэл захирлаар Х.Энхтайван томилогдон ажилласан.

2001 онд Улаанбаатар хотын авто замыг сайжруулах төслийн хүрээнд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар нийлүүлсэн зам барилга газар шорооны ажлыг хийж гүйцэтгэх 29 төрлийн машин механизм, тоног төхөөрөмж, лабораторийн багаж хэрэгслээр үйлдвэрлэлийн баазаа өргөтгөсөн нь санхүүгийн чадавхийг сайжруулахад гол үндэс болсон.

Хино маркийн автомашин 5 ширхэг

Асфальт дэвсэгч



Түүхчилсэн лавлах

WB93R ковш – 5 ширхэг



Сакай- индүү 2 ширхэг



Асфальтбетоны үйлдвэр

2005 оны 1 дүгээр сарын 5-нд “УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ” /ОНӨААТҮГ/ болсноор одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

Ингэснээр тус компани нь хотын ойр орчмын даваа гүвээ болон 18 чиглэлийн 133,8 км замын цас мөсийг цэвэрлэх арчлан хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэхээр болжээ. Үүнд:

Энэ хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудаас:

№	Гудамж, замын нэр	Он	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
	Хандгайт-Санзайн чиглэлийн авто зам барилгын ажил	2005	4 км	446.100.000
1	Их нарангийн зам барилгын ажил	2006	1,5 км	295.289.955
2	Токиогийн гудамжны авто зам шинэчлэлтийн ажил	2006	0,79 км	234.101.132

Түүхчилсэн лавлах


3	Хотын гудамж замын хэвтээ тэмдэглэгээ	2006	4000м-2	101.249.000
4	Чингэлтэй-Хайлаастыг холбосон зам барилгын ажил	2007	1.5 км	
5	Амгалан чиглэлийн авто замын шинэчлэлт	2007	1.1 км	
6	Хотын гудамж замын хэвтээ тэмдэглэгээ	2007	10000м-2	300.000.000
7	Багахангай дүүргийн авто зам барилгын ажил	2007-2008	1.97 км	
8	Хотын гудамж замын хэвтээ тэмдэглэгээ	2008	10406.6м-2	311.900.000
9	Зам тээвэр оновчтой төслийн хүрээнд Солонгос улсын хөрөнгө оруулалтаар хотын уулзваруудын гэрлэн дохиог цахилгааны найдвартай эх үүсвэрт холбох ажил	2008-2009	55	324.423.638
10	Офицеруудын ордны эскадрилын хөшөөний авто замын хучилт	2009	3100м-2	
11	Зайсангийн гүүрний хучилт	2009	2000 м-2	
12	Хотын гудамж замын хэвтээ тэмдэглэгээ	2009	5348.7 м-2	150.000.000

Байгууллагын товч түүх 2010-2012 он

Захирал	Д.Батэрдэнэ
Ерөнхий нягтлан бодогч	О.Цэвэлмаа, Бямбацэрэн, Б.Болормаа
Ерөнхий инженер	Т. Янжиндулам
Ажиллагсдын дундаж тоо	135
Машин механизм тоо	35

Байгууллагын бүтэц зохион байгуулалт

Түүхчилсэн лавлах



2010 онд хийгдсэн зам барилгын ажил



Саппорогийн аюулгүйн тойрог ба Гурвалжингийн гүүр хүртэлх 0,4 км 987.7 сая төгрөгийн төсөвт өртөг авто зам засвар шинэчлэлтийн ажил

Түүхчилсэн лавлах



БГД 11-р хорооны 1.4 км Төсөвт өртөг 372.6 сая төгрөг бүхий авто зам барилгын ажил



Цагдаагийн академийн уулзвараас Шархадны авто замын уулзвар хүртэлх 1,5 км 949.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий авто зам барилгын ажил

Түүхчилсэн лавлах

Зам засварын ажил

- Зуслангийн чиглэлийн 2000 м² талбайн засварын ажил 74.4 сая төгрөгийн өртөгтэй
- Зиг загийн хажууд 500 м² талбайн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг замын сангийн хөрөнгөөр 13.4 сая төгрөгийн өртөгтэй
- Бага тойруугийн замд 600 м² талбайд засварын ажил замын сангийн хөрөнгөөр 13.9 сая төгрөгийн өртөгтэй
- Нарны замын 200 м² талбайд засварын ажил замын сангийн хөрөнгөөр 7.5 сая төгрөгийн өртөгтэй
- Үндсэн хуулийн гудамжинд 200 м² талбайд урсгал засварын ажил 7.5 сая төгрөгийн өртөгтэй
- Бусад байгууллагын захиалгаар 123.5 сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэсэн

Зам арчлалтын ажил:

Нийт 6 чиглэлийн 50 км авто замуудад арчлалтын ажил хийсэн. Нийт төсөвт 64.0 сая төгрөг

Үүнд:

- Баянзүрхийн товчооны авто зам
- 22-н товчооны авто зам
- 7 буудал – Хандгайт – Санзай чиглэлийн авто зам
- Найрамдал зуслангийн чиглэлийн авто зам
- Нисэх - Биокомбинат чиглэлийн авто зам
- Айцын даваа чиглэлийн авто зам

Тэмдэг тэмдэглэгээний ажил:

- НАЗГ-н захиалгаар 40.1 сая төгрөгийн 772 ширхэг тэмдэг үйлдвэрлэсэн
- Бусад байгууллагын захиалгаар 32.4 сая төгрөгийн 687 ширхэг тэмдэг үйлдвэрлэсэн
- Термопластикаар 253.1 сая төгрөг 7415.5 м² зам талбайд хэвтээ тэмдэглэгээ хийсэн
- Будгаар 129.2 сая төгрөгийн 7621 м² зам талбайд хэвтээ тэмдэглэгээний ажил хийж гүйцэтгэсэн

Асфальтбетоны үйлдвэрийн ажил:

- Өөрийн хэрэгцээнд 4094.8 тн асфальтбетон
- Гадны байгууллагын захиалгаар 1017.5 тн асфальтбетон үйлдвэрлэж 117 106.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн


Төлбөртэй авто зогсоол байгуулах ажил

Түүхчилсэн лавлах

НИТХ-ын 2009.12.23 – ний өдрийн 4/27 дугаар тогтоолоор:

- Нийт 189 зогсоолыг 396.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн


Авто зогсоол-1 /Хангарьд ордон/
Уг зогсоолын талбай нь нийт 82 автомашины зогсоолтой, автомат төхөөрөмжтэй.



Авто зогсоол-2 /Спортын төв ордон/
Уг зогсоолын талбай нь нийт 64 автомашины зогсоолтой, автомат төхөөрөмжтэй.



Авто зогсоол-3 /УДЭТ/
Уг зогсоолын талбай нь нийт 43 автомашины зогсоолтой, автомат төхөөрөмжтэй.



2010 оны нийт борлуулалт 3727.0 сая.төг
2010 онд өөрийн хөрөнгөөр ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулахад хийгдсэн их засварын ажлууд: зорилгоор 69 452.0 мян.төгрөгөөр гадна болон дотор талд иж бүрэн засвар хийсэн

Түүхчилсэн лавлах



Конторын гаднах фасадыг 34 618.6 мян.төг-өөр засаж сайжруулсан.

Сургалтын өрөөг шинээр тохижуулж бий болгоход 5 348.8 мян.төгрөг зарцуулсан. Цаашид өөрсдийн нөөц бололцоогоор замчин, механизмчин сургаж ажлын байраар хангах бүрэн бололцоотой болсон.



Оффисийн дотор засвар



Засварын өмнө



Засварын дараа


Түүхчилсэн лавлах

Архивын өрөөний тохижилт



Өрөө хоорондын тусгаарлалт

Өрөөнүүдийн тохижилт



Тэмдэг, тэмдэглэгээний үйлдвэрт



Түүхчилсэн лавлах

Тэмдэг, тэмдэглэгээний үйлдвэрийн байр, ажилчдын ажлын байрыг 16 358.3 мян.төг-өөр засаж тохижуулсан.



Хэвлэх машин



Автогражын ажилчдын ахуйн байр



Автогражын ажилчдын ажиллах тав тухыг хангах зорилгоор шинээр ажилчдын ахуйн байр барьсан.

Ажилчдын хуучин байрлаж байсан

вагончик



Түүхчилсэн лавлах



Дотроо байрлах душ

Цэвэр, бохир усанд холбогдсон ариун цэврийн өрөө



Шинээр барьсан блокон хашаа
Авто гражийн болон Асфальтбетон
үйлдвэрийн 584 м блокон хашааг 14
950.4 мян.төг-р барьж байгуулсан.



Түүхчилсэн лавлах

2011 онд хийгдсэн ажил



2011 онд Сонгино хайрхан дүүргийн Таван шарын авто замын нарийссан хэсгээс Толгойт-Орбитын авто замын уулзвар хүртэлх 2,5 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил 2659.8 сая төгрөг



Энхтайвны өргөн чөлөө Олимпийн болон Их сургуулийн гудамжны уулзварыг нэгтгэж 4 замын уулзвар болгох 941564.1 сая төгрөгийн өртөгтэй, 0.5 км уулзварын өргөтгөл

Түүхчилсэн лавлах

2011 онд гүйцэтгэсэн зам засварын ажлуудаас:

- Толгойт-Орбитын уулзварын зүүн талд авто замын сэтэлгээний ажил 1.6 сая төгрөг
- Нефть Импорт Концернийн урд талын авто замын сэтэлгээний ажил 5.2 сая
- Таван шарын уулзварын баруун талд авто замын сэтэлгээний ажил 13.6 сая
- Саппорогийн аюулгүйн тойргийн сэтэлгээний ажил 3.0 сая
- Хойд зуслан чиглэлийн авто замын 3550 м² талбай бүхий урсгал засвар, нөхөөсний ажил 117 сая
- Халдвартын эмнэлгийн урд талын авто замын 1100 м² талбай бүхий засварын ажил 36.4 сая төгрөг
- Магадлашгүй 850 м² нөхөөсний ажил 29.0 сая
- Хан-Уул дүүргийн Туул гол дээрх Сонсголонгийн 288 у/м төмөр бетон гүүрийн урсгал засварын ажил 56.0 сая төгрөг
- Баянзүрх дүүргийн 11-р хороо Ногоон зоорь орчмын авто замын ус зайлуулах хоолой, хөвөө, далангийн ажил 33.4 сая төгрөг
- Баянгол дүүргийн 11-р хорооны 1.4 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил 59.3 сая төгрөг
- Нисэх онгоцны буудлын гаднах авто замын засварын ажил 18.2 сая төгрөг
- Эх нялхасын авто замын засварын ажил 7.2 сая төгрөг
- Баяр наадмын талбайн авто машины зогсоол 9.3 сая төгрөг

Түүхчилсэн лавлах



- 9677.4 м² талбайд тэмдэглэгээний ажил 258.7 сая төгрөг
- НАЗГ-ын захиалгаар 442 ширхэг, гадны байгууллагын захиалгаар 641 ширхэг нийт 1083 ширхэг тэмдэг үйлдвэрлэж 202.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн
- Баяр наадмын түр тэмдэг 2.0 сая төгрөг
- Авто замд 4257 ширхэг цацруулагч тоноглож 89.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн



24.8 сая төгрөгийн хайс арчлалт засварын ажил хийж гүйцэтгэсэн

Түүхчилсэн лавлах

Асфальтбетон үйлдвэр



Нийт 12983.3 тн асфальтбетон хольц үйлдвэрлэсэн. Үүнээс 4039.9 тн-г гадны байгууллагын захиалгаар, 8943.4 тн-г өөрийн хэрэгцээнд үйлдвэрлэж 884.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Үйлдвэрлэл дээрхи сургалт



УБЗЗА НӨУГазар нь НХХС, ЗТБХБС, ЭБЭХС-ын 2010 оны хамтарсан тушаалаар үйлдвэрлэл дээрх сургалт явуулах тендерт 2011 онд оролцож сургалтын эрх авсан. Замчин, Бетон арматурчин, Хүнд машин механизмын операторчины 3 сарын сургалт хөтөлбөр зохион байгуулж, өөрийн ажилчдаас 28 хүн (70%), гаднаас 12 (30%) хүн хамруулан хичээлийн программ ханган 100 хувь амжилттай төгсгөсөн. 20.4 сая төгрөгийн өртөгтэй.

Хөрөнгө оруулалт

2011 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 787.6 сая төгрөгийн 7 ширхэг авто замын машин механизмаар парк шинэчлэлт хийлээ. Үүнд:
Норд бенз



Түүхчилсэн лавлах

Асфальто дэвсэг



Авто ачигч



Ачааны авто машин



Экскватор, Хос булт индүү



Оффисын барилгыг 2 давхарлах өргөтгөлийн ажил



Түүхчилсэн лавлах

1994 – 2012 онуудад томилогдон ажиллаж байсан удирлагууд



1994-1997 он Б.Отгонсүрэн
1999-2001 он Б.Отгонсүрэн



2001 – 2005 он Х.Энхтайван

2005 – 2006 он Д.Бат-Эрдэнэ



2006 – 2010 он Ц.Шинээрэг

2010 – 2012 он Д.Бат-Эрдэнэ



1998-1999он Төмөрбаатар

2012 оны 8-р сараас 10-р сар хүртэл Ц.Арсландорж

Түүхчилсэн лавлах



2012 оны 10 сараас Ч.Бэлэгсайхан захирлаар ажиллаж байна.

МОНГОЛ АРОСЫН ХҮНДЭТ ЗАМЧИН ЯНЖИВЫН ШАЖИН ӨГҮҮЛЖ БАЙНА.



Алтан шар зам дагасан хүний амьдрал өөдрөг явдаг Монгол, Оросын “Хүндэт замчин” Я.Шажин Монголын авто замын салбарт 40 гаруй жил ажилласан ахмад замчин Я.Шажин гуайтай ярилцлаа. Тэрээр 1980-аад оны үед Зам барилга ашиглалтын трестэд бригадын даргаар ажиллаж байжээ. Шажин гуайн удирдсан тус бригад Улаанбаатар хотын зам талбайн засварын ажлыг олон жил чанартай хийж гүйцэтгэсэн тэргүүний хамт олон байсан талаараа хуучилсан юм.

-Та замын байгууллагад нилээд олон жил ажилласан ахмад замчдын нэг. Ажил мэргэжлийн гараагаа хэдийнээс эхэлж байсан тухайгаа дурсахгүй?

-Би 1964 онд тухайн үеийн сайд нарын зөвлөлийн тогтоолын дагуу зам барилгын ангид хөдөө орон нутгаас ажилчин элсүүлэх шийдвэрээр Улаанбаатар хотод шилжин ирж Хотын гүйцэтгэх захиргааны харьяа Зам ашиглалтын ангид 1965 онд нэгдүгээр зэргийн замчинаар орж хөдөлмөрийн гараагаа эхэлсэн. Ангийн дарга нь Балдангомбо гэж хүн байсан. Замчинаар ороод жил гаруй ажиллаад бригадын дарга болсон. Миний хувьд бригадын дарга, мастер гээд дандаа л удирдах ажил хийсэн дээ. Тэгэхэд манай Зам ашиглалтын анги тус бүр 15 хүнтэй хоёр бригадтай байсан. Миний ахалсан бригад төв талбайгаас Налайх, Тэрэлж, Гачуурт, Их бага тэнгэрийн ам хүртэлх бүх зам талбай, гүүр далан сувгуудын арчилгаа, хамгаалалт цэвэрлэгээ, нөхөн сэргээлт, засварын ажлыг хариуцан ажиллана. Нөгөө бригад нь хотын зүүн талыг хариуцдаг. Ойролцоогоор 60 гаруй км зам талбай, далан сувгийн арчилгаа, хамгаалалт,

Түүхчилсэн лавлах

цэвэрлэгээг хийлгэсэн. Манай анги хотын замын эвдрэл, гүүр, шонгийн засвар үйлчилгээний ажлыг хариуцдаг байсан. Мөн 20-оод машин механизмтай гражтай, одоогийн 100 айлын 9-р дэлгүүрийн хажууд байрладаг байлаа. Тэр үед Зам ашиглалтын анги Хотын захиргааны харьяанд байсан юм. Хотын замын хэвийн үйл ажиллагааг явуулах нь бидний үүрэг байсан даа.

-Таныг ажиллаж байх хугацаанд Зам ашиглалтын ангийн нэр нь өөрчлөгдөж үйл ажиллагаа өргөжсөн гэдэг юм билээ?

-Намайг ажиллаж байх хугацаанд гурван удаа нэрээ өөрчилсөн. Улаанбаатар хотын Зам барилгын засвар ашиглалтын трест гэж шинээр байгуулаад Доржпүрэв гэдэг хүн даргаар нь томилогдсон. Энэ трестэд Зам ашиглалтын ангийн хоёр бригадыг нийлүүлсэн юм. Трест болсноос хойш гадаадын зочид төлөөлөгчдыг ирэхэд мандуулдаг төрийн далбаануудыг арчлах, мужааны цех, төмрийн цех, замын тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хашлага, боржур хийдэг цехтэй том байгууллага болсон. Тэгээд 1990-ээд оны үед зах зээл гараад нилээд бужигнаж эхэлсэн. Тухайн үед замын ажил өвөл зунгүй үргэлжилдэг байсан. Одоо бол улирлын чанартай болчихож. Өвөл замын хажуу талын зах ирмэг руу шороо хийж тэгшлэх, үер усанд эвдэрсэн зам, даланг засах, ирэх жилийн гүүрний засварт хэрэглэх шонг үйлдвэрлэх, жижиг гүүрний явах ангийг засах, чулуун өрлөг, бэхэлгээ зэргийг өвөл зунгүй хийдэг байлаа.

-Та олон жил удирдах ажил хийж байсан хүний хувьд өөрийн гэсэн арга туршлагатай байсан байх. Танай бригадыг тухайн үедээ шилдэг ажилчидтай тэргүүний хамт олон байсан гэдэг юм билээ?

-Намайг анх замын ажилд ороход 1945 онд олзлогдсон Өвөр монголчууд манай бригадад ажиллаж байгаад хоёр улсын хэлэлцээрээр ял зэм нь цагаадаад нутаг буцсан. Тухайн үед шоронгоос гарсан хүмүүсийг зам барилгын ажилд авдаг байсан. Янз бүрийн хүмүүс л ирж ажиллана. Ер нь хүнтэй ажиллана гэдэг амаргүй, хүнээ сайн судалж хүний арга барилыг олох нь чухал. Хүн бүрт хийх ажлыг нь сайн танилцуулж ойлгуулах хэрэгтэй. Манай бригадын хамт олон дотор байгууллагын аварга, хотын аварга, улсын аварга ч хүмүүс байсан. Тэр үед чинь социалист хөдөлмөрийн төлөө бригад гэж байлаа шүү дээ. Манай бригад социалист хөдөлмөрийн болзлыг гурван удаа хангасан тэргүүний хамт олон байсан. Би 1984 онд Бүх холбоотын авто замын сайдын тушаалаар ЗХУ-ын “Хүндэт замчин” цол тэмдэгээр Монголоос анх удаа шагнуулсан. Миний хувьд намын бодлого шийдвэрийг хэрэгжүүлсэн идэвх зүтгэлийг үнэлж “Халамжлан хүмүүжүүлэгч” болсон. 1989 онд Ардын их хурлын депутатаар хуучнаар Найрамдлын район \одоо Баянзүрх дүүрэг\-оос сонгогдож байлаа . Одоо энэ УБЗЗАкомпанийн байрлаж байгаа газарт нийтийн байр байсан. Их олон жил болсон болохоор айлууд нь мөөнцөртөөд хүн амьдрах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан. Тэгээд би их хурлын депутат байхдаа хөөцөлдөж байгаад 13-р хорооллыг ашиглалтанд ороход нь нийтийн байранд байсан 20 гаруй айлыг оруулж байсан.

Түүхчилсэн лавлах

-Хийсэн бүтээсэн ажлаа олон жилийн дараа эргээд харахад бахархах сэтгэл төрөхөөс гадна танд олон сайхан дурсамжууд үлдсэн байх?

-Би чинь анх замын тухай ойлголтгүй хөдөөний хүн замчин болж байлаа. Миний санаанаас гардаггүй нэг дурсамж байдаг юм. Дээхнэ үед замын асфалтыг гараар тараадаг байсан. Харин одоо бол укладчекаар тараадаг болсон. Нэг өдөр манайхан зам дээр асфалтаа асгаад тарааж байсан чинь хүмүүс ирээд “Та нар яах гэж ийм сайхан зам дээр нүүрсний хог асгаад байгаа юм” гээд загнаж байж билээ. Зам бол их буянтай өгөөжтэй, алтан шар зам дагасан хүний амьдрал өөдрөг явдаг. Олсон хэдэн мөнгө нь орлого зарлаганд шингээстэй сайн явдаг гэж настайчууд биднийг хүндэлдэг байсан. Өвчин зовлон ороогоод, ядуу зүдүү яваа хүнийг лам нар үзээд замын чулуу түү, энэ яваа насандаа хийсэн муу юм арилдаг гэж настайчууд хуучилдаг байсан. Намайг ажиллаж байх үед модон гүүр их байдаг байлаа. Баянзүрхийн модон гүүрний засварын ажлыг хийж байхад нилээд настай өвгөн ирээд “Хүү минь чамаас нэг юм гуйх гэсэн юм, ахдаа жаахан мод өгөөч” гэсэн. Би ч дотроо гүүрний хуурай модноос түлээний мод л гуйх гэж байгаа биз гэж бодоод “ав ав” гэсэн. Тэгсэн нөгөө өвгөн гүүрний хуучин модноос 10 см гаруй мод аваад “За боллоо хүү минь их баярлалаа” гэдэг юм байна. Би гайхаад “Та ийм жижиг модоор юу хийх гэж байгаа юм” гэж асуусан. Тэгсэн нөгөө өвгөн би нэг охинтой, миний охиноос гарсан жаахан хүүхэд их уйлаад өвчин зовлон ороогоод байдаг юм. Энэ мод чинь их учиртай. Зам гүүрийн ажил гэдэг олон хүний хүч хөдөлмөр, машин техник гээд их хүчирхэг ажил. Энэ модоор чинь тоглоом хийж хүүгийнхээ өлгийд уяхад сайн байдаг юм гэсэн. Одоо бодоход өвчин зовлон ороогоод байгаа хүүхдийг ингэж домнодог байсан юм болов уу. Ер нь зам гүүрийн ажил гэдэг их буянтай үйл гэж бодож явдаг. Алтан шарын замын ачаар би сайн явсан.

Ярилцсан Б.Цэцэгмаа

2012.10.19

Түүхчилсэн лавлах

Шагналтнууд

Алтан гадас		Хөдөлмөрийн хүндэт медаль	
1.	Ж.Намдов	1.	Ж.Намдов
2.	Баасанхүү	2.	С.Самдан
3.	С.Самдан	3.	Д.Жамц
4.	Г.Жигмэд	4.	Ж.Батсүх
5.	Ц.Шинэзориг	5.	Г.Эрдэнэчимэг
6.	Ц.Эрдэнэцогт	6.	Д.Насанбат

Тэргүүний замчин

1. Баадай
2. Ж.Намдов
3. Мижиддорж
4. Содномдаржаа
5. Рэнцэн
6. В.Ванлин
7. Ж.Баасанхүү
8. Д.Баасандорж
9. Ц.Лхагвасүрэн
10. Г.Цэрэндэжид
11. С.Төрбат
12. О.Дэлгэр
13. Б.Намжил
14. М.Олонбаяр
15. Ж.Батсүх
16. З.Тунгалаг
17. Г.Эрдэнэчимэг
18. Ц.Шинэзориг
19. Л.Өлзийсайхан
20. К.Гулбахит
21. Ж.Болдбаатар

Онц тээвэрчин

1. Ж.Намдов
2. М.Олонбаяр
3. Б.Жадамбаа

2011 оны үйл ажиллагааны үр дүнгээрээ
Нийслэлийн харъяа байгууллагуудаас шалгарч
Нийслэлийн Засаг даргын өргөмжлөл хүртсэн хамт олон.



2012.02.08

Түүхчилсэн лавлах



УБЗЗА ОНӨААТҮГ газрын хамт олон /2009 он/



УБЗЗА ОНӨААТҮГ газрын хамт олон Шинэ техник хүлээн авхад 2011 он

Түүхчилсэн лавлах



1990 он Автогражийн Гүрсэд даргатай хамт олон



УБЗЗА ОНӨААТҮГазар 66 өндөр настантай /2008 он/

Түүхчилсэн лавлах

ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ.

Өнөөдөр манай архивын сан хөмрөгт Авто зам барилгын “Улаанбаатар” компани, “Дохио үйлдвэр”, “Улаанбаатар зам засвар, арчлалт компани” зэрэг газруудын 1954 оноос эхэлсэн цаасан суурьтай хадгаламжийн нэгж **842**, дүрс бичлэг, гэрэл зураг, цахим баримт бүгд 12 хадгаламжийн нэгж хадгалагдан ашиглагдаж байна.

Жилд дунджаар 90 орчим баримтаар сан хөмрөгөө баяжуулах ажлыг зохион байгуулж ирлээ.



Баримтын хадгалалтын зохион байгуулалт нь баримтыг оновчтой зөв байрлуулах, тэдгээрийн өөрчлөлт хөдөлгөөн, физик химийн шинж чанарт хяналт тавих, нөөц болон ашиглалтын

Түүхчилсэн лавлах

хөмрөг үүсгэх зорилгоор баримтын хуулбар хувь үйлдэх, гэмтэж муудсан баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх арга хэмжээний тогтолцоо юм.



Түр хадгалах хадгаламжийн нэгж



70 жилийн хадгаламжийн нэгж

Байнга хадгалах хадгаламжийн нэгж



Баримт үдэгч, чийгшүүлэгч



- 2000 он, 2007 онуудад Нийслэлийн архивын газартай байгуулсан гэрээний дагуу мэргэжлийн ажилтнаар байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлгэж жилийн эцсийн тайлан тэнцэл, даргын

Түүхчилсэн лавлах

тушаал зэрэг 1954-2005 оны 211 байнгын хадгаламжийн нэгжийг данс бүртгэл үйлдэн батлуулж НАГ-т шилжүүлэн хөмрөг үүсгэсэн байдаг ба, 1991-2003 оны 15 хэрэг буюу **112** хадгаламжийн нэгжид устгах хэргийн акт үйлдэн устгагдсан байна.

- 2010 онд НАГ-ын мэргэжилтний удирдлагын дор, зөвлөгөө чиглэл авч өөрсдийн хүчээр 1997-2000 оны төрийн, 1969-2009 оны 70 жил, 2006-2009 оны байнга хадгалах баримтуудын гарчиг, он цагийн хязгаар, хуудасны тоо зэргийг бүртгэлтэй тулган шалгаж залруулсан ба, ББНШК-ын гишүүдийн оролцоотойгоор хэсэгчилсэн ЭШТБ хийж данс бүртгэл үйлдэн НАГ-ын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар батлуулсан.
- Хадгалах хугацаа дууссан 1997-2000 оны 80 хэрэг, бүртгэлд тусгагдаагүй 1991, 1993 оны 33 хэрэг нийт **113** хэргийг устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн мөн хурлаар хэлэлцүүлэн батлуулж устгагдсан болно.
- Өнөөдрийн байдлаар НАГ-ын сан хөмрөгт байнга хадгалах **211** хадгаламжийн нэгж архивлагдан ашиглагдаж байна.
- Баримтын тооллогыг тогтоосон хугацаанд явуулж акт үйлдэж байсан ба “Архивын баримт”-д нэгдсэн тооллого явуулах тухай Нийслэлийн засаг даргын 2011 оны 03-р сарын 24-ны өдрийн 250 дугаар захирамж, удирдамж, НАГ-аас гаргасан зөвлөмж гарын авлагыг удирдлага болгон байгууллагын захирлын тушаалаар томилогдсон комисс төлөвлөгөө график гарган заавар журмыг үндэслэн тооллогыг хугацаанд явуулж дүн мэдээ, илтгэх хуудсыг зохих газарт хүргүүлсэн болно.
- Байгууллагын архив нь “Үндэсний архивын газар”-ын архивын ажлын заавар, холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон боловсруулсан Архивын дүрэм, Дэд захирлаар ахлуулсан ББНШК-ын ажиллах дүрэм, Захиргаа, Санхүү, Үйлдвэрлэлийн гэсэн зохион байгуулалтын 3 нэгж, нэгжийн даргатай зохион байгуулагдан харилцан хүлээх үүрэг, хариуцлагын түвшинд хамтран ажиллаж байна.

Архив, албан хэргийн боловсруулалт, хөтлөлтийг өнөөгийн төрөөс тавигдаж байгаа бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс:

Захирлын 2010 оны 52 тоот тушаалаар: “Хадгаламжийн нэгж” бүрдүүлэх журам, баримт хүлээн авах хуваарийг батлуулан хувийг ажилтнуудад хувилан тарааж мөрдөхөөс гадна арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага материал тараах, хяналт тавих, ажилтнуудын тайлан хэлэлцэхэд үзүүлэлт болгон дүгнэх ажлууд тогтмол хийдэг болсон.

НАГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж арга зүйн зөвлөгөө авах, сургалт семинар, үзүүлэх сургуульд оролцох зэргээс суралцаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хамтран ажиллах гэрээний дагуу, сургалт явуулах, удирдамж боловсруулан тестээр шалгалт авах, үйл ажиллагааны явцад үүсэн гарч байгаа бичиг баримтын боловсруулалт, хадгалалт хамгаалалтанд үзлэг шалгалт хийж зөрчлийг ажилтан бүрээр гарган танилцуулж ажил сайжруулах арга хэмжээ авч ажиллаж үр дүнд хүрч байгаа зэргээс цухас дурдлаа.

Түүхчилсэн лавлах

2012 ОН

Байрлал: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Жуковын өргөн чөлөө

2012 онд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, Нийслэлийн засаг даргыг төлөөлж Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээ, Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд бүхий л ажлаа чиглэл чиглэлээр урьдчилан төлөвлөж, “Байгууллагын эрхэм зорилго” болох Замын хөдөлгөөнд оролцогчдын ая тухтай, аюулгүй байдлыг хангасан нийслэлийн замын сүлжээ бий болгохын тулд зам барилга, засвар арчлалт, замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээний ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж замын материалыг чанар стандартын дагуу үйлдвэрлэх, шинэчлэн сайжруулах, ашиглалтын байнгын найдвартай ажиллагааг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байжээ.

Тус байгууллага нь аж ахуйн тооцоотой өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, автозамын засвар арчлалтын ажил хариуцсан үйл ажиллагааны чиглэлтэй өөрийн 36 машин механизмтай, Асфальтобетон үйлдвэр, Замын тэмдэгийн үйлдвэр, 50 машины гражтай.

2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 12 тоотойр” Байгууллагын бүтэц орон тоо, бүтэц зохион байгуулалтын схем”-ийг шинэчлэн баталсан захирлын тушаалтай. Мөн оны 9, 11 дүгээр сард цалингийн сүлжээ, цалинг шинэчлэн тогтоосон.

НЗД-ын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дугаар А/663 захирамжаар үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан байна.

НЗД-ын захирамжаар Үйлдвэрийн газрын удирдлагаар Цахиагийн Арсландоржийг 2012 оны 08 дугаар сарын 22 ны өдрөөс томилогдон ажиллаж байсан ба сарын дараа буюу 2012 оны 09 дугаар сарын 27-ны өдрөөс Чадраагийн Билэгсайханыг томилон ажиллуулж байна.

Захирлууд өөрчлөгдөн томилогдсон энэ хугацаанд бүтцийн өөрчлөлтүүд хийж шинээр орон тоо нэмэгдэж томилгоонууд тойрч өнгөрсөнгүй ээ.

Тус үйлдвэрийн газар нь захиргаа удирдлага төлөвлөлтийн хэлтэс, захиргаа санхүү, үйлдвэрлэлийн, техникийн гэсэн 3 албатай 2.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 1.6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, жилд 10 км зам барилга угсралтын ажил болон 20000 м² хүртэл авто зам засварын ажлыг бүрэн хийх хүчин чадал бүхий 36 машин механизм, нийт 137 ажиллагсадтайгаар /144 орон тоотой/ дараах чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнд:

- Авто зам барилга, Зам засвар арчлалт
- Авто зам, Замын байгууламжийн арчлалт, хамгаалалт
- Замын тэмдэг, тэмдэглэгээ, үйлдвэрлэл
- Асфальтбетон хольцын үйлдвэрлэл

Түүхчилсэн лавлах

- Уян шонгийн арчлалт хамгаалалт
- Төлбөртэй авто зогсоол ажиллуулах

1. АВТО ЗАМ БАРИЛГА , ЗАМ ЗАСВАР.

Ерөнхий инженер Т.Янжиндуламын удирдлага зохион байгуулалтан талбайн инженер Х.Батдорж,Д.Даваабаяр,Геодезийн инженер Д.Энхтуяа , Инженер С.Энхцэцэг,Э.Баасанжав,Г.Баяржаргал, замчдын бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Хийж гүйцэтгэсэн ажлуудаас:

- Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо Эскадрилын хөшөөнөөс Цэргийн их сургууль, Шар хадны зам хүртэлх нийт 2,2 км авто замын шинэчлэлтийн ажлыг тус үйлдвэрийн газар тендер шалгаруулалтанд шалгаран гэрээ байгуулан ажиллаж 2012 онд 70% буюу **1,540,0** сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн



Газар чөлөөлөлт, дулааны шугам ажлын зурагт тусгагдаагүй, бороо усны байгууламж өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан зураг өөрчлөгдөх ,гэрэлтүүлгийн төсөв өөрчлөх болсон зэргээс шалтгаалан гэрээний хугацаа сунгагдан цаг хугацаа алдсан бөгөөд он дамжуулан хийж дуусгах юм байна.

Түүхчилсэн лавлах


- Автобусны зогсоолын талбай шинээр хийх ,өргөтгөн засварлаж шинэчлэхэд **29.8** сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэлээ.



- Нийслэлийн авто замын газартай байгуулсан гэрээгээр ЗЦГ-ын өмнөх авто машины төлбөртэй авто зогсоолыг байгуулхад нийт төсөвт өртөгийн 80% буюу **120.0** сая төгрөгийн өртөгтэй зогсоолын ажил хийж гүйцэтгэв. Үлдэгдэл ажлыг 2013 оны 05 дугаар сард гүйцэтгэн гэрээг дуусгавар болгох юм байна.



Түүхчилсэн лавлах



- Авто замын засвар, арчлалтынажил



- Баянзүрх дүүргийн 4-р хороо, 15-р хороолол. Энхтайвны өргөн чөлөөнөөс хуучин такси бааз, Жуковын музей хүртэлх авто замын засварын ажил **844.5** сая төгрөг. Хойт зуслан чиглэлийн авто замын 3200 м2-тад 139.2 сая төгрөгийн урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.153,1

Түүхчилсэн лавлах



ГҮҮРИЙН УРСГАЛ ЗАСВАР

- Энх тайвны гүүр 284.7 сая төгрөг.
- Яармагийн гүүр 53.7 сая төгрөг.
- Арслантай гүүр
- Зайсангийн гүүр 229.1 сая төгрөг нийт 567.5 сая төгрөгийн ажлыг иргэн Б.Ууганбаяртай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлжээ.

АВТО ЗАМ ГҮҮРИЙН АРЧЛАЛТ ХАМГААЛАЛТ.

- Нисэх –Биокамбинат чиглэлийн 7 км
- Наадамчдын замын уулзвараас-Түргэний голын гүүр 10 км
- Орбитаас-Найрамдал 13 км
- Чингэлтэй- Санзай 18 км
- Баянзүрхийн товчоо 1 км
- 22-ын товчоо 1 км нийт 50 км авто замын арчлалтаар 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг хариуцан гүйцэтгэхэд:
- УБ хотын ерөнхий менежерийн 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах схемийн дагуу “Улаанбаатар зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ нь 2012.12.20-2013.01.01-ний өдөр өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах хуваарийг шинэчлэн гаргаж, ажиллах зохион байгуулалтыг тушаалаар батлан, ажиллах хүч, нэрс, холбогдох утсыг төв штаб болон бусад холбогдох байгууллагуудад хүргэн хариуцлагатай жижүүр 24 цагаар гаргаж, мэдээллийг цаг тухайд НЗДТГ, НЗАА, НОБГ болон НАЗГ, холбогдох байгууллагуудад утсаар болон цахим шуудангаар хүргэн

Түүхчилсэн лавлах

ажиллаж байна. Уг өдрүүдэд 14 удаагийн дуудлагаар арчлалтыг хийж цасыг түрэн ,хайлуулах бодис, давс, элс цацан гулгааг арилгалаа.

- Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр, Монгол улсын Боловсролын их сургуулийн өмнөх 32 метр урт, 18метрийн өргөнтэй нүхэн гарцын арчлалтын ажлыг гэрээгээр 40.0 сая. Гүйцэтгэлээр 30.3 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэж санхүүжигдсэн.

АСФАЛЬТО БЕТОН ҮЙЛДВЭР. Байрлал: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг

гурвалжингийн гүүрний урд. Үйлдвэрийн дарга Ц.Сэнгээгийн удирдлага зохион байгуулалтанд



инженер Ц.Туяабаатар,нярав
П.Отгон,оператерчин

Д.Байгаль,А.Амартүвшин,Б.Мөнхбаатар,
Г.Баярмагнай туслах ажилтан, ,
Болдбаатар,Оюунбадрах нарын
бүрэлдэхүүнтэйгээр ажилласан хамт
олон.

2012 онд замын хучилтын гол түүхий эд
болох 10.0 тн асфальтобетон
үйлдвэрлэх гэрээ хийж төлөвлөсөн
боловч гадны байгууллагын захиалгаар
өнгө болон суурийн асфальт 757.9 тн,
байгууллагын хийж гүйцэтгэсэн авто зам
барих засварлах хэрэгцээнд 6284.6 тн,
нийт **7402.4** тн асфальтбетон хольц
үйлдвэрлэж төлөвлөгөөг биелүүлээгүй
байна. Борлуулалт **147.3** сая төгрөг

Асфальто бетон үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахаар засвар техникийн үйлчилгээнд 16.3 сая төгрөг зарцуулсан байна

Цаашид үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүчин чадлаараа ажиллахад одоогийн үйлдвэр нь техник технологи нь хоцрогдсон, 2000 онд ашиглалтанд орсон актлах хугацаа хэтэрсэн, орчин үеийн шаалдлагыг хангахгүй зэрэг асуудлыг бэлтгэн “Удирдах зөвлөлийн хурал”-аар хэлэлцэн 2013 онд хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулахаар зохих газруудад саналаа боловсруулан өгөөд байгаа болно.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАХ,ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР.

Үйлдвэрийн инженер Б.Өмүртэй ,даамал М.Болот нараар удирдуулсан
О.Алтай,М.Баяржаргал,Э.Баярсайхан,А.Дашзэвэг,Б.Еркетэй,Н.Нямсүрэн,

Түүхчилсэн лавлах

О.Хадбаатар Д.Насанбат,Ш.Цэцгээ нарын хамт олны хийж бүтээснийг тоймлон хүргэж байна.

- Улаанбаатар хотын гудамж замуудад хийгдэх хэвтээ тэмдэглэгээ.НАЗГ-тай хийсэн Гэрээгээр 350.0 сая

Нийслэлийн авто замын газартай байгуулсан гурвалсан гэрээний үндсэн дээр Замын Цагдаагийн газрын захиалгаар 10.402.9 м² талбайг термопластикаар,445.8 м² талбайг авто замын будгаар, бусад байгууллага иргэдийн захиалгаар 24м², нийт 12.319.1м²-т **268,5 сая**



төгрөгийн тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн дүн мэдээтэй.

Гудамж Замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, заалт үйлдвэрлэл.

НАЗГ-тай хийсэн Гэрээгээр 100.0 сая

Замын цагдаагийн газрын захиалгаар 1199 ш тэмдэг үйлдвэрлэж суурилуулсан ,ба тэмдэг, бусад байгууллагын захиалгаар **1347** ш тэмдэг, нийт **2546** тооны тэмдэг , заалт. үйлдвэрлэж **186,8** сая төгрөгийн борлуулалт хийжээ

СХД-ийн 4, 5-р хороонд байрлах 2,5 км замд **1300** м туузан хашлага,



бетонон түмбэ **100** ширхэгийг суурилуулан хүлээлгэн өгсөн зургийг харуулав. **Төсөвт өртөг**

Түүхчилсэн лавлах



Мөн Нийслэлийн засаг даргын 2012 оны 532 тоот захирамжын дагуу Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах, ачааллыг зохицуулах зорилгоор зорчих хэсгийн 1 дүгээр эгнээгээр 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн зөвхөн нийтийн тээврийн үйлчилгээний автобус, троллейбусыг давуу эрхтэй зорчуулах болсонтой холбогдуулан нийтийн тээврийн хэрэгслийг саадгүй зорчуулахаар зорчих хэсгийн 1 дүгээр эгнээг бусад эгнээгээс болон замын эсрэг урсгал тусгаарлах **1192** ш уян шонг шинээр суурилууллаа.

2012 оны 11,12 дугаар сард 2312 тооны уян шонг засварлах, арчлах, эвдэрч гэмтсэнийг нөхөн суурилуулах, цэвэрлэгээ арчлалтыг хийхэд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 24,5 сая төгрөгийн зардал гарсан .

НЗАА-наас гарсан захирамжинд зөвхөн тус үйлдвэрийн газарт шилжүүлэх тухай заасан болохоос суурилуулах, засварлаж арчилж тордоход гарсан зардлыг санхүүжилт хариуцах байгууллагыг тусгаагүй байсан. Энэ тухай асуудлыг НЗАА, НТСан, НАЗГ-т хандсан боловч санхүүгийн тайлант жил дуусч Төрийн сан хаасан тул санхүүжигдээгүй. Иймд 2013 оны төсөвт тусгагдсан зардлаас гаргуулахаар хүсэлтээ тавиад байна.

Түүхчилсэн лавлах



Хуучин уян шонг сольж байгаа нь

АВТО МАШИНЫ ТӨЛБӨРТЭЙ ЗОГСООЛ

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 12 дугаар сарын 23 ны өдрийн 4/27 дугаар тогтоолоор Хангарьд ордоны өмнөх 82, Улсын драмын эрдмийн театрын өмнөх 43, Спортын төв ордоны 64, нийт 189 авто машины зогсоолын тоног төхөөрөмжийг хариуцан ажиллуулж замын санд 200 сая төгрөг төвлөрүүлэх болсон байна. Тоног төхөөрөмжийн үнэ 396.6 сая төгрөг бөгөөд хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн байна.

- Авто зогсоолуудын үйл ажиллагааг жигд ханган ажиллуулхад Авто зогсоолын зохион байгуулагчийн удирдлаганд 3 ээлжээр төлбөр хураагч зохицуулагч ажиллаж **112,5** сая төгрөгийн орлоготой ба Нийслэлийн төсөвт 50.0 сая төгрөг төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байгаа. Зохион байгуулагчаар Дашням, Наран, Одбаяр.
- Ажиллагсад: М.Өлзиймаа, Б.Алтантуяа, Г.Шижиртуяа, Д.Дуламрагчаа, Д.Гунгаасамбуу, Э.Өнөрсайхан, Ж.Амаржаргал, Ж.Баатарцогт, Ж.Баттөмөр, М.Мөнхбаатар,
- Т.Отгончимэг, Н.Хишигдэлгэр, Т.Байгалмаа, О.Сэргэлэн.

АВТО ГРАЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ.

Байрлал: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг

Авто гражийн дарга ашиглалтын инженер тоо бүртгэгч **Жолоочоор** М.Олонбаяр, Б.Жадамба, С.Батсүх, С.Лхагважав П.Баярцогт, Д.Улаанхүү, Д.Дандарсүрэн, Н.Нямдавчамба, С.Самбуу, Ц.Батбаатар, Л.Ганбаатар, О.Ганбаатар, Г.Элбэгсайхан, Ж.Дамдинсүрэн, Ш.Тогтохбаяр

Механизмчинаар А.Хуягочир, Ө.Болдбаатар, Н.Пүрэвдорж, Ө.Баярцогт Э.Мөнхбат, Б.Энхбаатар, З.Азбаяр, гагнуурчин, засварчнаар Х.Цогбаяр, С.Лхагвадорж, сахиул Д.Арслан,

Түүхчилсэн лавлах

Үйлчлэгчээр М.Баяраа нарын бүрэлдэхүүнтэй хамт олон тус үйлдвэрийн газрын бүх үйл ажиллагаанд хэрэгцээтэй авто замын машин механизм, тоног төхөөрөмжөөр ханган ажиллахын зэрэгцээ гадны байгууллага, иргэдэд үйлчил иржээ.

Үйл ажиллагааг тогтвортой явуулах, техник хэрэгслийн насжилтыг уртасгах зорилгоор нийт 12 машин механизмд 53.1 сая төгрөгийн урсгал засвар хийгдсэн.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗАСВАР ТОХИЖИЛТЫН ТУХАЙ.

2012 оны төсвийн тодотголыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэхэд тус үйлдвэрийн газарт 800,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авахаар төсөвлөгдсөн бөгөөд уг арга хэмжээний дагуу том оврын ачааны автомашин 2, дунд оврын крантай ачааны машин 1, бага оврын ачааны автомашин 1, универсаль трактор 1, замын далангийн хүнд даацын индүү 1, замын гар индүү 1, автозамын тэмдэг тэмдэглэгээ хийх термопластик тавих машин, будгийн машин, цахилгаан үүсгүүр, лист зүсэгч машинуудын техникийн үзүүлэлт, үнэ өртөгийг судлан захилга өгсөн.



Түүхчилсэн лавлах

БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, ҮР ДҮН.

Нийт борлуулалт	мян/төг-өөр	4.531.297.1	Үүнээс:
• Зам барилга, засвар арчлалт, тохижилт		2.526.912,9+202,5	
• Авто замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг заалт үйлдвэрлэн суурилуулхад			
282,430,0		282430.0	
• Авто замын тэмдэг тэмдэглэгээ		268515,3	
• Туузан хашлага сүүрилуулахад		51000.0	
• Авто замын тусгаарлах хайс арчлахад		31303,1	
• Бетонон түмбэ суурилуулхад		9000.0	
• Хурд сааруулагч шинээр тавихад		97817,7	
• 4 замын уулзварт гэрлэн дохио суурилуулсан		83556,2	
• 3 замын уулзварт гэрлэн дохио суурилуулсан		56943,5	
• Асфальтобетөн үйлдвэрлэлээс		147295.1	
• Төлбөрт зогсоолын орлого		112509.4	
• Нүхэн гарцны түрээс болон арчлалтаар		46495,1	
• Бусад орлого /авто машины тавилт		1787.4	
Нийт зардал		4.460.457,1	
Ашиг, алдагдал		70.840.0	
Авлага		659.506,3	
Өглөг		-1.414.265.5	

АЖИЛТНУУДЫН МЭДЛЭГИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛХЭД.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 3 өдрийн сургалтанд хамрагдвал зохих 25 ажилтныг хамруулж 1.0 сая төгрөг, Төрийн захиргааны удирдлага сэдвээр Магистр хамгаалах сургалтын төлбөрт

ХНМ У.Баямаад 1.0 сая төгрөг, замын инженер Д.Даваабаярыг Төсөвчний анхан шатны 14 хоногийн сургалтанд 180.0 мянган төгрөг, инженер С.Энхцэцэгийг замын зөвлөх инженерийн сургалтанд тус тус хамруулж 130.0 мянган төгрөг нийтдээ 2310.0 мянган төгрөгийг зохих сангаас зарцуулжээ.

НИЙГМИЙН АСУУДАЛД.

Тус үйлдвэрийн газар нь дундчаар 140 өөд ажиллагсдын ар гэрийн ахуй хангамж

Түүхчилсэн лавлах

болон өөр олон асуудлыг шийдвэрлэхэд зохих хувь нэмрийг оруулсан нь лавтай.

- 2012 оны 9 ,11дүгээр сард Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолыг үндэслэн зэрэглэлээр цалингийн жишгийг тогтоон захирлын тушаал гарган мөрдөн ажиллаж байгаа бөгөөд цалин хөлсийг 27.7 %-иар нэмэгдүүлсэн гэж тооцоолжээ.

ЧӨЛӨӨТ ЦАГ

Ажиллагсдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын төрлийн тэмцээнд амжилт гаргахад нь захиргааны зүгээс бэлтгэлийг зориулалтын газарт хийлгэж төлбөр тооцоог хариуцаж байсан нь тэмцээнд амжилттай оролцох нөхцөл бололцоог хангасан гэж болно. Тухайлбал:

- Монголын авто замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны нэрэмжит” ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ТӨЛӨӨХ СПОРТЫН ТЭМЦЭЭН”-д 16 баг оролцож хурд хүчээ сорьсоноор Гар бөмбөг, Сагсан бөмбөгийн төрөлд Б.Болормаа ахлагчтай ҮЭХ-ны багийн хамт олон 1-р байр эзэлж 2012.02.05 –ний өдөр ӨРГӨМЖЛӨЛ мөнгөн шагналаар шагнагдсан. Эмэгтэйчүүдийн дунд явагдсан ганцаарчилсан тэмцээнд шатраар Б.Болормаа алт,Тенисээр хүрэл, медалийг тус тус хүртсэн ба багийн дүнгээр 2-р байрт шалгарч мөнгөн медаль хүртсэн.
- Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ-ын дэргэдэх ҮЭХ-ноос “Монгол улсад авто зам үүсэж хөгжсөн”-ий 83 жилийн ойн арга хэмжээнд зориулж 2012.10.27-нд зохион байгуулсан 6 төрөлт тэмцээнээс И.Батзориг ахлагчтай “ЗАХИРГААНЫ БАГ” Гар бөмбөг,Сагсан бөмбөгийн 2 төрөлд 1-р байрт шалгарч ӨРГӨМЖЛӨЛ,Алтан медаль ,мөнгөн шагналаар, мөн 2012.10.28-нд Захирлын нэрэмжит “СПОРТ НААДАМ 2012” ТЭМЦЭЭН”-д багийн дүнгээр Б.Болормаа ахлагчтай Захиргааны багийн хамт олон “Шилжин явах цом”, алтан медаль,өргөжлөл, мөнгөн шагнал, эмэгтэй, эрэгтэйчүүдийн ганцаарчилсан тэмцээнд Шатарт Б.Болормаа, Өмиртэй ,Тенисээр Л.Өлзийсайхан, Б.Болормаа Биллярдаар Ч.Билэгсайхан нар шалгарч алтан медалийг тус тус хүртжээ.
- 2012 оны 11дүгээр сард “Монгол улсад авто зам үүсэж хөгжсөн”-ий 83 жил, “Эрдэнэ зам” ХХК –ны 15 жилийн ойг тохиолдуулан ЗТЯамны авто замын бодлого зохицуулалтын газар, Монголын авто замчдын холбоо,Нийслэлийн авто замын газар, Авто замын хяналт эрдэм шинжилгээ судалгааны төвтэй хамтран 2012 оны “САЛБАРЫН АВАРГА” шалгаруулах 20 баг, 6 төрөлт тэмцээнд оролцон Гар бөмбөгөөр Б.Болормаа ахлагчтай баг шалгарч мөнгөн медаль,мөнгөн шагнал, мөн ганцаарчилсан тэмцээнд шатар, тенисээр мөн Б.Болормаа хүрэл медалийн эзэн болсон амжилтаар 2012 оноо үджээ.

зураг

2012 ОНЫ АМЖИЛТ БҮТЭЭЛ

Түүхчилсэн лавлах

- Мэргэшсэн санхүүчдийн “Төгсгөн” холбооноос тэргүүн дээд шагнал “ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА” цол өргөмжлөл. зураг
- Нийгэмд стандарт хэвшүүлэх сангаас”НИЙГЭМД ХАРИУЦЛАГАТАЙ ТҮНШ” байгууллага цол өргөмжлөл.

ХОЕР. ХӨМРӨГИЙН БАРИМТЫНТҮҮХ .

1.Хөмрөгийн баримтын он цагийн хязгаар,тоо хэмжээ

2011оны 12дугаар сарын 31-ний байдлаар архивын сан хөмрөгт Авто зам барилгын “Улаанбаатар” компани, “Дохио үйлдвэр”, “Улаанбаатар зам засвар, арчлалт компани” зэрэг газруудын 1954 оноос эхэлсэн цаасан суурьтай хадгаламжийн нэгж 847, дүрс бичлэг, гэрэл зураг, цахим баримт бүгд 18 хадгаламжийн нэгж хадгалагдан ашиглагдаж байна.

Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу Хадгаламжийн нэгж бүрдүүлэх журам, баримт хүлээн авах хуваарийг Захирлын 2010 оны 52 тоот тушаалаар батлуулан хувийг ажилтнуудад хувиалан тарааж мөрдөхөөс гадна арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага материал тараах, хяналт тавих, ажилтнуудын тайлан хэлэлцэхэд үзүүлэлт болгон дүгнэн 2011 баримтуудыг архивт хүлээн авсан тухай Захирлын зөдлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргасан болно.

2.Хөмрөгийн баримтын бүрэлдэхүүн ,тоо хэмжээнд орсон өөрчлөлт.

Хөмрөгийн бүрэлдэхүүний тоо хэмжээнд өөрчлөлт ороогүй.

3.Баримтын бүрэн бүтэн байдал,хадгалалт хамгаалалтын талаар

Архивын баримт бичгийн хадгалалт ,хамгаалалт шинж чанарт нөлөөлж буй хүчин зүйлүүд болох тохиромжтой шаардлага хангасан нөхцөлийг бүрдүүлэх,агаарын хэт хуурайшилт,нарны шууд тусгал, агаарын бохирдол, байгалийн болон гал,усны зэрэг олон хүчин зүйлсээс хамгаалахад ихэнхи хувийг эзлэх цаасан суурьтай баримтуудын хадгалалт хамгаалалтад тавих шаардлагыг хангуулан ажиллаж байна.

Жилд дунджаар 90 орчим баримтаар сан хөмрөгөө баяжуулах ажлыг зохион байгуулж ирлээ.



Түр хадгалах хадгаламжийн нэгж

Түүхчилсэн лавлах

70 жилийн хадгаламжийн нэгж



Байнга хадгалах хадгаламжийн



үйлдэх, гэмтэж муудсан баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх арга хэмжээний тогтолцоо юм.

Үндэсний архивын газрын даргын 59 дүгээр тушаал, байгууллагын ажлын үндсэн зааврыг үздэслэн хөмрөгийн баримтыг он цагийн хязгаар, үйл ажиллагааны чиглэл агуулга, ач холбогдолоор нь түр, байнга, 70 жил гэж данс бүртгэл үйлдэгдсэн болно.

Хадгаламжийн нэгжүүдийг байрлуулахдаа байнга, түр, 70 жил зааврын дагуу байрлуулж он цагийн хязгаар, оны заагуурыг хийснээр эрэлт хайлтыг хялбар хөнгөн шуурхай болгон байгууллага иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

5. Хөмрөг үүсгэгч байгууллагын архивын сан хөмрөгт бусад байгууллага, хувь хүмүүсийн баримт хадгалагдаж буй талаархи мэдээлэл

Байгууллагын хөмрөгт бусад байгууллага, хувь хүний талаархи сан хөмрөг байхгүй.

6. Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагаа

Байгууллагын архив нь “Үндэсний архивын газар”-ын архивын ажлын заавар, холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон боловсруулсан Архивын дүрэм, Дэд захирлаар ахлуулсан БНШК-ын ажиллах дүрэм, Захиргаа, Санхүү, Үйлдвэрлэлийн гэсэн зохион байгуулалтын 3 нэгж, нэгжийн даргатай зохион байгуулагдан харилцан хүлээх үүрэг, хариуцлагын түвшинд хамтран ажиллаж байна.

- Өнөөдрийн байдлаар НАГ-ын сан хөмрөгт байнга хадгалах **211** хадгаламжийн нэгж архивлагдан ашиглагдсан хэвээр байна.

Архив, албан хэргийн боловсруулалт, хөтлөлтийг өнөөгийн төрөөс тавигдаж байгаа бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс:

НАГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж арга зүйн зөвлөгөө авах, сургалт семинар, үзүүлэх сургуульд оролцох зэргээс суралцаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түүхчилсэн лавлах

2013 он

Байрлал: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Жуковын өргөн чөлөө

Үйлдвэрийн газрын захирлаар С.Ганбаатар, Б.Ганзориг захирамжийг хавсаргав.

Ерөнхий нягтлан бодогчоор Б.Солонго, Д.Батмягмар

Ерөнхий инженерээр Т.Янжиндулам, Өлзийсайхан

2013 онд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, Нийслэлийн засаг даргыг төлөөлж Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээ, Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд бүхий л ажлаа чиглэл чиглэлээр урьдчилан төлөвлөж, “Байгууллагын эрхэм зорилго” болох Замын хөдөлгөөнд оролцогчдын ая тухтай, аюулгүй байдлыг хангасан нийслэлийн замын сүлжээ бий болгохын тулд зам барилга, засвар арчлалт, замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээний ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж замын материалыг чанар стандартын дагуу үйлдвэрлэх, шинэчлэн сайжруулах, ашиглалтын байнгын найдвартай ажиллагааг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байжээ.

Тус байгууллага нь аж ахуйн тооцоотой өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, автозамын засвар арчлалтын ажил хариуцсан үйл ажиллагааны чиглэлтэй өөрийн 38 машин механизмтай, Асфальтобетон үйлдвэр, Замын тэмдэгийн үйлдвэр, 50 машины гражтайгаар үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Бүтцийн дагуу үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “Нийслэл хотын авто замын засвар, арчлалт, зам барилгын ажил, гудамж замын тэмдэг заалтыг үйлдвэрлэх, тэмдэглэгээ” хийж гүйцэтгэж ажиллах үүрэгтэйгээр ажиллаж байгаад Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 9 дүгээр сарын 04-ны 100 дугаар тогтоол. Нийслэлийн засаг даргын 2013 оны 09 дүгээр сарын 09 -ны А/846 тоот захирамжаар татан буугдаж Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт эрх үүргийг нь шилжүүлхэд дуусгалтын тайлан тэнцлээр тайлант жилдээ 2,6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 3,3 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгөөр 2,130,545,5 мянган төгрөгийн борлуулалт хийж 2,135,679,8 мянган төгрөгийн зардал гаргаж 5134,3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хоёр . ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ.

Өнөөдөр манай архивын сан хөмрөгт Авто зам барилгын “Улаанбаатар” компани, “Дохио үйлдвэр”, “Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ ” зэрэг газруудын 1969 оноос

Түүхчилсэн лавлах

эхэлсэн цаасан суурьтай баримт , 2012 оноос дүрс бичлэг, гэрэл зураг, цахим баримт хадгалагдан ашиглагдаж байна.

Жилд дунджаар 90 орчим баримтаар сан хөмрөгөө баяжуулах ажлыг зохион байгуулж ирлээ.

Баримтын хадгалалтын зохион байгуулалт нь баримтыг оновчтой зөв байрлуулах, тэдгээрийн өөрчлөлт хөдөлгөөн, физик химийн шинж чанарт хяналт тавих, нөөц болон ашиглалтын хөмрөг үүсгэх зорилгоор баримтын хуулбар хувь үйлдэх, гэмтэж муудсан баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх арга хэмжээний тогтолцоо юм.

- 2000, 2007онд Нийслэлийн архивын газартай байгуулсан гэрээний дагуу мэргэжлийн ажилтнаар байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийж жилийн эцсийн тайлан тэнцэл, даргын тушаал зэрэг 1954-2005 оны 211 байнгын хадгаламжийн нэгжийг данс бүртгэл үйлдэн батлуулж НАГ-т шилжүүлэн хөмрөг үүсгэсэн байдаг ба, 1991-2003 оны 15 хэрэг буюу **112** хадгаламжийн нэгжид устгах хэргийн акт үйлдэн устгагдсан байна.
- 2010 онд НАГ-ын мэргэжилтний удирдлагын дор, зөвлөгөө чиглэл авч өөрсдийн хүчээр ЭШТБ хийж 1997-2000 оны түрийн, 1969-2009 оны 70 жил, 2006-2009 оны байнга хадгалах баримт, 1997-2000 оны 80 хэрэг, бүртгэлд тусгагдаагүй 1991, 1993 оны 33 хэрэг нийт **113** хэргийг устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдсэн ба НАГ-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан данс бүртгэлтэй.

Өнөөдрийн байдлаар НАГ-ын сан хөмрөгт байнга хадгалах **397** хадгаламжийн нэгж архивлагдан ашиглагдаж байна.

Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГазар татан буугдаж байгаа тул 1969 -2012 оныг дуустал хугацааны 70 жил, байнга, түр , зураг төслийн баримтанд ЭШТБ ажлыг НАГ-ын мэргэжлийн арга зүйн зөвлөгөөний тусламжтайгаар хийж гүйцэтгэхэд:

Байнга, түр хадгалах баримтыг задалж байгууллагын даргын тушаал болон бусад байнга хадгалах заалт бүхий баримт, зохион байгуулалт, үйл ажиллагааны баримтуудыг түүх эрдэм шинжилгээ, лавлагаа мэдээллийн ач холбогдол, хадгалах хугацаа, хэргийн бүрдлээр нь тус бүрд нь эмхлэн цэгцэлж баримтын нэр төрөл, он, сар, өдөр, дугаараар нь дараалуулан байнга, түр, хадгалах, устгах баримтаар ангилах техник ажлуудыг хийлээ. Үүнээс тодруулах:

1. Хадгалах хугацаа дууссан 2001 оны 1-3 сарын цалингийн хүснэгтийг сугалан авч 70 жилийн 111 дугаартай Х/Н-д нэмж үдэв.
2. Хадгалах хугацаа дууссан 2002 оны кассын баримтаас цалингийн олгох, дэлгэрэнгүй хүснэгтийг сугалан авч 115, 116, 117 дугаартай Х/Н -тэй нэгтгэн нэг Х/Н болгон 70 жилд бүртгэсэн.

Түүхчилсэн лавлах

- 3.Хадгалах хугацаа дууссан 2003 оны кассын баримтаас цалингийн хүснэгтийг сугалан авч 70 жилийн 119-д бүртгэлтэй Х/Н-д үдэн бүртгэлд авсан хуулбар хувийг устгалын актанд оруулсан.
4. 2007-2012 онуудын 70 жилд бүртгэлтэй байсан нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн Х/Н-ээс байгууллагын тооцооны нэгдсэн тайланг сугалан байнгын баримтанд бүртгэлд авсан.
5. Хадгаламжийн бүх нэгжийг бүртгэлтэй тулгахад 70 жилийн Х/Н-ээс карт цалингийн хүснэгтийг хавтсанд тодорхойлсон бригад ,цех, тасгийн нэрээр бүртгэлд авсан,хэт зузаан баримтуудыг хувааж 2 нэгж болгон үдсэн.
- 6.Байгууллагын хувийн хэрэгт хадгалагдаж байсан тухайлбал Х/Н-ийн бүртгэлүүд,түүхчилсэн лавлах зэргийг Х/Н болгон бүртгэлд авсан.
- 7.Ажилтнуудын гар дээрээс Х/Н болгон үүсгээгүй Тендерийн саналын баримт бичиг,/тендерт оролцоогүй/ ажлын зураг,төсөв, бусад цаасан суурьтай баримтын авч цэцглен бүртгэсэн.
8. 2001-2010 онуудын санхүүгийн тайлан балансаас 4-р улирлын баланс татварын тайланг сугалан байнгын бүртгэлд Х/Н үүсгэн бүртгэсэн.
- 9.2008-2010 оны цалингийн хүснэгтийг задлан тасаг албадаар нь 1-12 сараар төрөлжүүлэн үдсэн.
- 10.Хадгалах хугацаа дууссан 1969 -2012 оны 32 хэрэг, 201 хадгаламжийн нэгжийг устгах бичгийн түүвэр жагсаалтанд орууллаа.
- 11.ЭШТБ хийх явцад шаардлага хангахгүй баримтанд сэлбэн засалт хийж хавтаснуудыг шинээр хавтаслаж үдэж бичилтийг хийсэн болно .
- 12.Байнга хадгалах 2006-2012 оны 176,түр хадгалах 1998-2012 оны 474 , 70 жил хадгалах 1969-2012 оны 145,устгах хэргийн акт үйлдсэн 201 ,2009-2012 оны зураг төслийн 32 бүгд 1028 хадгаламжийн нэгжийн данс бүртгэлийг үйлдэснээс байнга хадгалах 176 Х/Н-ийг бүртгэлээр, 2005 оноос өмнөх 10 Х/Н-ийг жагсаалтаар тус тус хүлээлгэн өглөө.